



**БАЯНХОНГОР АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН
ХУРЛЫН ТОГТООЛ**

2017 оны 10 сарын 05 өдөр

Дугаар 129

Номгон

Г
Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн
129,4 км авто замын төслийн гүйцэтгэлийн явцтай
танилцах ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.4, 20.1.14 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын Тогтвортой хөгжлийн бодлогод тусгагдсан Баруун аймгуудыг нийслэл хоттой холбох их бүтээн байгуулалтын ажил Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129,4 км авто замын төслийн гүйцэтгэлийн явцтай танилцах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Ажлын хэсгийн ахлагч: Ц.Отгонбаяр-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга

Нарийн бичгийн дарга: Д.Ихбаяр-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд: Н.Баярсайхан-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Э.Энхбат-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч, Тэргүүлэгч

Ж.Пүрэвсүрэн-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын төлөөлөгч

Н.Бямбадорж-Аймгийн Мэргэжлийн хяналтын газрын дарга

Т.Норов-Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга

М.Хосбаяр-Аймгийн Стандартчилал, хэмжилзүйн хэлтсийн дарга

Д.Юндэнбазар-Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн Олон нийттэй харилцах хэлтсийн дарга

А.Дорж-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

Б.Батгэрэл-Гадаадын иргэн харьяатын газрын Баянхонгор аймаг хариуцсан төлөөлөгч

0117093

2. Ажлын хэсгийн удирдамжийг хавсралтаар баталсугай.
3. Ажлын хэсгийн дүгнэлтийг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчид, Засаг даргын зөвлөлийн бүрэлдэхүүнд 2017 оны 10 дугаар сард багтаан танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Ц.Отгонбаяр/-д даалгасугай.
4. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга /С.Үнэнбуян/-д үүрэг болгосугай.



Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын
Тэргүүлэгчдийн 2017 оны 10 дугаар сарын
05-ны өдрийн 129 дүгээр тогтоолын хавсралт

БАЯНХОНГОР-БАЙДРАГИЙН ГҮҮР ЧИГЛЭЛИЙН
129,4 КМ АВТО ЗАМЫН ТӨСЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН
ЯВЦТАЙ ТАНИЛЦАХ АЖЛЫН ХЭСГИЙН УДИРДАМЖ

ЗОРИЛГО: Баруун аймгуудыг нийслэл хоттой холбох их бүтээн байгуулалтын ажил Баянхонгор-Байдрагийн гүүр чиглэлийн 129,4 км авто замын төслийн гүйцэтгэлийн явцтай танилцаж, гэрээний гүйцэтгэлтийн явцыг дүгнэх

ХУГАЦАА: 2017 оны 10 дугаар сарын 15-20-ны өдрүүдэд

ШАЛГАЖ ТАНИЛЦАХ: Дээрх авто замын бүтээн байгуулалт нь /59,79 сая ам долларын өртөг бүхий /төслийн гүйцэтгэгч “Шанхай Констракш Групп” ХХК гэрээний дагуу хоёр жилийн хугацаанд хийж гүйцэтгэх/ замын хүчин чадлын хувьд 7 метрийн өргөн, 6 см-ийн зузаан асфальт бетон хучилттай, 2 талдаа 1,5 метрийн өргөн хайрган хөвөөтэй, 3 дугаар зэрэглэлийн авто зам болох ажлын/гэрээний үүргээ хэрхэн биелүүлж байгаа байдалтай танилцах

- Түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахад тавих ерөнхий шаардлага хэрхэн хангагдаж байгаа байдал

-Аймгаас гэрээний дагуу ажилчин авсан байдал

-Татварт орлого төвлөрүүлэх байдал

-Иргэдээс ирүүлсэн зарим гомдол бодитой эсэхийг шалгах

-Гадаадын иргэд нь зөвшөөрөлтэй эсэх

-Машин, тоног төхөөрөмж, техник хэрэгслэл нь гэрчилгээ, зөвшөөрөл, даатгалтай эсэх

-Цаашид гүйцэтгэгч компанийтай хамтран ажиллах санал дүгнэлт